



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 02 сарын 08 өдөр

Дугаар 40

Улаанбаатар хот


Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэнд, спортын сайдын 2016 оны багцын XVII.2.1.12 Спорт заалын барилга /Булган, Хангал сум, Хялганат тосгон/-ны 1,121,194,418 (нэг тэрбум нэг зуун хорин нэгэн сая нэг зуун ерэн дөрвөн мянга дөрвөн зуун арван найман) төгрөгийн гэрээний хэрэгжилтэнд техникийн хяналт тавих эрхийг Булган аймгийн Засаг дарга /Д.Эрдэнэбат/-д шилжүүлсүгэй.

2. Эрх шилжүүлсэнтэй холбогдуулан ажлын гүйцэтгэл, тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын Санхүү, эдийн засгийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Т.Баярсайхан/-д даалгасугай.

САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ОЮУНБААТАР

080133